

ЗҮҮНБАЯН ТӨМӨР ЗАМ ХХК-ИЙН 2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Нэг. Ерөнхий зүйл

1.1 “Зүүнбаян төмөр зам” ХХК нь Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор баталсан төсөвт үндэслэн 1,250,985.00 мянган төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг боловсруулж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 24-ны өдрийн А/31 тоот тушаалаар батлуулсан. Үүнээс эхний хагас жилийн байдлаар 627,231.00 төгрөгийн худалдан авалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг үндэслэн зохион байгуулж ажилласан байна.

1.2 Тухайн жилийн худалдан авах төлөвлөгөөнд тусгалгүйгээр худалдан авсан бараа, ажил, үйлчилгээ байхгүй болно.

1.3 Хэрэгжээгүй худалдан авалт 623,754.00 төгрөг байна.

Үүнд:

- Тээврийн хэрэгсэл худалдан авах – 60,000.0 мянга
- Хэвлэл мэдээлэл, арга хэмжээ – 104,000.0 мянга
- Автомашин түрээс – 117,520.0 мянга
- Хурлын өрөөний тоног төхөөрөмж, хяналтын камер – 30,250.0 мянга
- Эрүүл мэндийн үзлэг, оношилгоо – 21,600.0 мянга
- ISO стандарт нэвтрүүлэх – 18,000.0 мянга
- Зөвлөх үйлчилгээ – 113,400.0 мянга
- Мэргэшүүлэх, мэдлэг олгох сургалт – 32,000.0 мянга
- Стандартын сургалт – 17,500.0 мянга

Компанийн дотоод үйл ажиллагаатай холбоотойгоор дээрх худалдан авалтуудыг сүүлийн хагас жилд зохион байгуулахаар төлөвлөсөн.

Тендер шалгаруулалт үргэлжилж байгаа нийт 1 төсөл байна.

1.4 Тендер шалгаруулалтын үнэлгээг тендерийн хүчинтэй байх хугацаанд нь холбогдох хууль, журамд нийцүүлэн хийж ажилласан.

1.5 Худалдан авах ажиллагааны явцад гарсан зөрчил дутагдалгүй.

1.6 Тайлант хугацаанд тендер оролцогчдоос Сангийн яаманд манай компанийн тендер шалгаруулалттай холбоотой гарсан гомдол, санал байхгүй.

1.7 Манай компани худалдан авалтын төлөвлөгөөний хүрээнд дотоодын үйлвэрээс худалдан авах чанар сандартын шаардлага хангасан, тохирлын баталгаатай барааны жагсаалт"-д багтсан бараа бүтээгдэхүүнийг худалдан авч, дотоодын үйлдвэрийг дэмжих тухай Монгол улсын Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хоёр. Худалдан авах ажиллагааны цахим системийг ашиглалтын талаар

2.1 Худалдан авах ажиллагааны цахим системээр зарласан тендер шалгаруулалтын тоо нийт тендер шалгаруулалтын 100 хувь буюу нийт 8 байна.

4.2 Гэрээний хэрэгжилтэнд захиалга гаргасан нэгжийн төлөөллийг оролцуулан хяналт тавьж, гэрээ дуусгавар болмогц гэрээ дүгнэсэн акт үйлдэж, талуудаар гарын үсэг зуруулж баталгаажуулан ажиллаа.

4.3 Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналтыг цаашид улам үр дүнтэй болгох санал, зөвлөмж байхгүй болно.

ХЯНАСАН: ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Д.БАНЗРАГЧ

БОЛОВСРУУЛСАН: ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Б.ОТГОНБААТАР



"ЗҮҮНБИЯН ТӨМӨР ЗАМ" ХХК-ИЙН 2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛГААНЫ ЕРӨНХИЙ ТАЙЛАН

№	Тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, хүчин чадал, багцлалт		Батлагдсан төсөвт өртөг (мян. төг)	Эрх шилжүүлсэн эсэх /ГЕЗ-н нэр/, шийдвэрийн дугаар, огноо	Гэрээний дүн (мян төг)	Гүйцэтгэгчийн нэр, гэрээний дугаар		Худалдан авах ажиллагаанд мөрдсөн журам	Худалдан авах ажиллагаанд мөрдсөн хугацаа						Уламжлалт / цахимаар зарласан эсэх	Тайлбар, тодруулга
									Үнэлгээний хороо байгуулсан огноо	tender.gov.mn-д урилга нийтэлсэн огноо	Сонин хэвлэлд тендерийн урилга нийтэлсэн огноо	Гэрээ байгуулах эрх олгосон огноо	tender.gov.mn-д дүн нийтэлсэн огноо	Гэрээ дуусгаж, дүгнэсэн огноо		
1	2		3	4	5	6		7	8	9	10	11	12	13	14	15
1	Компьютер түүний дагалдах хэрэгсэл	Багцгүй	191,200.00	Үгүй	176,663.82	Киберком ХХК	ЗТЗ/ 202102001	НТШ	2021/ 02/10	2021/0 3/04	-	2021/04/ 09	2021/04 /12	2021/05 /10	Цахим	
2	Багц-1 Санхүүгийн програм хангамж	Багцтай	14,550.00	Үгүй	14,107.50	Интерактив биаи ХХК	ЗТЗ/ 202102002	ХА	2021/ 03/30	2021/0 4/09	-	2021/04/ 22	2021/05 /11	2021/12 /24	Цахим	
	Багц-2 Ухаалга ERP систем	Багцтай	6,600.00	Үгүй	5,940.00	Айблсофт ХХК	ЗТЗ/ 202102002	ХА	2021/ 03/30	2021/0 4/09	-	2021/04/ 22	2021/04 /22	2021/12 /24	Цахим	
3	Тавилга эд хогшил	Багцгүй	74,852.00	Үгүй	44,620.00	Хашхан ХХК	ЗТЗ/ 202102007	НТШ	2021/ 02/10	2021/0 3/05	-	2021/04/ 09	2021/04 /12	2021/06 /24	Цахим	
4	Багц-1 Принтерийн хор	Багцтай	3,624.00	Үгүй	2,838.00	Элит хангамж ХХК	ЗТЗ/ 202103036	ХА	2021/ 03/03	2021/0 3/23	-	2021/04/ 06	2021/04 /06	2021/12 /24	Цахим	
	Багц-2 Бичгийн цаас, бичгийн хэрэгсэл	Багцтай	13,440.00	Үгүй	8,799.587	Зөв өнгө ХХК	ЗТЗ/ 202103036	ХА	2021/ 03/03	2021/0 3/23	-	2021/05/ 19	2021/05 /19	2021/12 /24	Цахим	
5	Шатахуун нийлүүлэх	Багцгүй	71,160.00	Үгүй	68,986.40	Петростар ХХК	ЗТЗ/ 202102019	НТШ	2021/ 03/03	2021/0 3/09	2021/03 /09	2021/04/ 22	2021/04 /22	2021/12 /24	Цахим	
6	Багц-1 Хөдөлмөр хамгааллын ажлын хувцас	Багцтай	36,500.00	Үгүй	33,187.00	Асралтбаян хайрхан ХХК	ЗТЗ/ 202103035	НТШ	2021/ 03/23	2021/0 4/02	-	2021/05/ 10	2021/05 /10	2021/10 /15	Цахим	
	Багц-2 Хөдөлмөр хамгааллын ажлын гутал	Багцтай	31,000.00	Үгүй	30,602.00	Койн хаус ХХК	ЗТЗ/ 202103035	НТШ	2021/ 03/23	2021/0 4/02	-	2021/05/ 10	2021/05 /10	2021/10 /15	Цахим	